

БНХАУ-ААС МОНГОЛ УЛСАД СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ГАО ШУМАО МОНЦАМЭ АГЕНТЛАГИЙН СУРВАЛЖЛАГЧТАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА

Асуулт: Монгол, Хятад хоёр орны сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцаа өргөжин хөгжиж байна. Энэхүү харилцаа, хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг та хэрхэн үнэлж байна вэ?

Гао Шумао: Сүүлийн жилүүдэд Хятад, Монгол хоёр орны сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцаа өргөжин хөгжиж, хоёр улсын дээд хэмжээний харилцан айлчлал тогтмолжиж, бүх салбарын хамтын ажиллагаа тасралтгүй гүнзгийрч байна. Би хувьдаа, Хятад, Монгол хоёр улсын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцааны утга агуулгыг “улс төрийн хувьд харилцан итгэлтэй, эдийн засгийн хувьд харилцан ашигтай, утга соёлын хувьд харилцан хүртээлтэй, аюулгүй байдлын хувьд харилцан тустай” гэсэн дөрвөн зүйлээр хураангуйлан өгүүлж болно гэж үзэж байна.

Улс төрийн хувьд, Хятад, Монгол хоёр улс нөгөө талынхаа бүрэн эрх, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэж, энх тайван, хөгжил дэвшил, хамтын ажиллагааны замаар замнан, бүс нутгийн хийгээд олон улсын хамтын ажиллагаандаа харилцан ойлголцох, харилцан дэмжих байр суурь баримталж байна. Энэ бүхэн нь манай хоёр орон улс төрийн хувьд харилцан итгэлцэх таатай үндэс суурийг бүрдүүлж байгаа юм. 2006 онд хоёр улсын Парламент, Засгийн газар, улс төрийн намууд хоорондын харилцаа байнга хөгжиж ирсэн нь харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх шулуун дардан замыг нээж байна. Энэ онд, Хятадын засгийн газар Хятадын Улс төрийн Зөвлөлдөх зөвлөлийн орлогч дарга Шу Куанди-г Хятад Улсын даргын тусгай элчийн хувиар Монголд илгээж, “Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой”, баяр

наадмын ёслолд оролцлоо, одоо Монгол улсын Ерөнхий сайд ойрын үед БНХАУ-д айлчлах гэж байна. Эдгээр чухал харилцан айлчлал нь Хятад, Монгол хоёр орны ард түмний харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх таатай үндэс суурь болж байна.

Эдийн засгийн хувьд, Хятад, Монгол хоёр улсын хооронд “эрх тэгш, харилцан ашигтай, харилцан туслалцаж, хамтдаа хожих” хамтын ажиллагааны зарчим хэрэгжиж, хоёр талын худалдаа түргэн хурдацтай хөгжиж байна. Хятад улс олон жилийн турш Монгол улсын худалдааны хамгийн том түнш, хамгийн их хөрөнгө оруулагч орон хэвээр байна. Энэ оны эхний 9 сард, хоёр улсын худалдааны хэмжээ 1 тэрбум 63 сая ам. долларт хүрч, өмнөхөөс бараг нэг дахин нэмэгдээд байна. Түүний дотор Монгол улсаас БНХАУ-д хийсэн экспортын хэмжээ 757 сая ам. доллар, Хятадаас оруулсан импортын хэмжээ 306 сая ам. доллар, Монгол улсын Хятад улстай хийсэн худалдааны ашигтай тэнцэл 451 сая ам.доллар болоод байна. Өөрөөр хэлбэл, Монгол улсын энэ жилийн худалдааны тэнцэл ашигтай гарч байгаа нь чухамдаа хятад-монголын худалдаанаас оруулж буй хувь нэмэр болж байна. Түүнчлэн хоёр улсын мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, уул уурхай, дэд бүтцийн зэрэг салбарын хамтын ажиллагаа бас улам тогтвортой өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Соёлын хувьд, сүүлийн хоёр жилд Хятад, Монгол хоёр улс соёлын өдрүүд харилцан зохион байгуулсан нь соёлын салбарын харилцаа солилцоонд ихээхэн үр ашигтай түлхэц боллоо. Эдүгээ Монгол улсын хөгжим, дуу бүжиг, хувцас гоёл, түүнчлэн уртын дуу, хөөмий, морин хуурын тоглолт зэрэг нь хятадын ард түмний таашаал сонирхлыг ихээхэн хүлээж байна. Үүний зэрэгцээ, хоёр улсын харилцан солилцож буй оюутны тоо

байнга өсөн нэмэгдэж, Монголын залуучууд улам олноор БНХАУ-д очиж, хятад хэл болон бусад мэдлэг мэргэжил эзэмшиж, Хятадын залуучууд Монголд ирж, хэл болон урлагийн мэргэжилд суралцаж байна. Монголын хятад судлаач Хятадын алдарт сонгодог бүтээл Күнзийн “Шүүмжлэл өгүүлэл” болон “Сүнзийн дайтахуйн ухаан” зэрэг зохиолыг монгол хэлнээ орчуулан хэвлэсэн нь Монголын ард түмэн Хятадын эртний соёл, уламжлалт гүн ухааны сэтгэлгээг ойлгож таних хэрэгт чухал хувь нэмэр оруулж байгааг би туйлын баяртайгаар харж байна. Хятад, Монгол хоёр улс соёлын хувьд харилцан суралцууштай зүйл маш олон байгааг онцлон хэлэх нь зүйтэй. Цаашид бид улам бүр чармайх ёстой юм.

Аюулгүй байдлын хувьд, олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт, хөгжлийг дагалдан, олон улсын уламжлалт бус аюулгүй байдлын далд аюул улам бүр өсч байна. Хятад, Монгол хоёр улс 4710 км урт хилийн шугамтай билээ. Уламжлалт бус аюулгүй байдлын хүрээнд хамтран ажиллах орон зай маш өргөн юм. 2005 онд Хятад, Монгол хоёр улсын хоёр дахь удаагийн хилийн хамтарсан шалгалт албан ёсоор дууссан. Энэ удаагийн хамтарсан шалгалтын үр дүнд манай хоёр улсын хил улам бүр тогтвортой, улам бүр энх тайван, улам бүр харилцан хамтран ажиллах хил болоод байна. Хятад, Монгол хоёр улсын хилийн бүс нутагт ноцтой томоохон ямар ч хэрэг явдал гарч байгаагүй бөгөөд хоёр тал гал түймрээс сэргийлэх, халдварт өвчнөөс сэрэмжлэх, янз бүрийн хэлбэрийн улс дамнасан гэмт хэргийг таслан зогсоох зэрэгт улам бүр ойр нягт, эв найртай хамтран ажиллаж байгааг хэлье.

Асуулт: Монгол, Хятад хоёр улсын төр засгийн удирдагчид дээд хэмжээнд тогтмол харилцан айлчилж байна. Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдын БНХАУ-д хийх айлчлалын ач холбогдлыг та хэрхэн үнэлж байна вэ?

Гао Шумао: Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд энэ сарын сүүлчээр БНХАУ-д албан ёсоор айлчилна. Энэхүү айлчлал нь хоёр улсын харилцааны хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Юуны өмнө, энэхүү айлчлал нь хоёр улсын дээд хэмжээний удирдагчдын жил

тутмын уулзалтын давтамжийг хадгалж байна. Хятад, Монгол хоёр улсын хооронд шийдвэрлэгдээгүй асуудал ч байхгүй, шийдвэрлэж үл чадах асуудал ч байхгүй гэж би хувьдаа үздэг. Хятад, Монгол хоёр улс айл хөрш орнууд, хөрш орнууд гэдэг чинь та бидний өдөр тутмын амьдрал дунд байдаг хөрш айл л гэсэн үг. Хөршүүд эе найртай айлсан сууж, бие биенийхээрээ орж гарч, амар мэндээ мэдэлцэж, аль алиндаа тус нэмэр болж явдаг, хол хөндий байх учиргүй билээ. Түүн лүгээ нэгэн адил, хоёр улсын засгийн газар хооронд тогтмол уулзан учирч, хоёр орны удирдагчид тогтмол харилцан айлчилж байваас, хятад монголын сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцаа тууштай хөгжих нь дамжиггүй.

Хоёрдугаарт, энэхүү айлчлалын үеэр хоёр тал олон салбарын хамтын ажиллагааны асуудлаар санал бодлоо өргөн хүрээнд солилцох болно. Миний мэдэж байгаагаар, М.Энхболд ерөнхий сайд Хятадад айлчлахад Монголын бизнесийн хэсэг бас дагалдан явж, Бээжинд хятадын бизнесийн салбарынхантай уулзалт, яриа хэлэлцээ хийх бөгөөд энэ нь хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны түвшинг дээшлүүлж, агуулгыг нь баяжуулахад идэвхтэй нөлөө үзүүлэх нь мэдээж юм.

Гуравдугаарт, миний мэдэж байгаагаар, М.Энхболд Ерөнхий сайд энэ удаа бас манай улсын Синьзян Уйгурын өөртөө засах оронд айлчилна. Тийнхүү айлчлах нь хоёр тал баруун бүс нутгийн хамтын ажиллагааг урагшлуулахад идэвхтэй түлхэц үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Асуулт: Хятад улс баруун бүс нутгийг ихээр хөгжүүлэх стратеги хэрэгжүүлж байгаа нь дэлхий дахины анхаарлыг татаж байна. Энэ нь хөрш орон-Монгол улсын хөгжилд ч тустай нь мэдээж. Хятадын баруун бүс нутаг, тухайлбал, СУӨЗО хийгээд Монгол улсын баруун бүс нутаг хоорондын харилцаа хамтын ажиллагааны талаар та юу хэлэхсэн бол?

Гао Шумао: Би Хятад улсын шинэтгэл, гадаадад нээлттэй бодлогыг хэрэгжүүлж ирсэн 20-иод жилийн замналыг маш товчхон хэдэн үгээр танилцуулахыг хүсч байна. Дэн Сяопин шинэтгэл, гадаадад нээлттэй

бодлогын ерөнхий хөгжлийн стратегийг дэвшүүлсний дараа, Хятадын засгийн газар зүүн бүс нутгийн эрэг орчмын шинэтгэл, нээлттэй бодлого, баруун бүс нутгийг ихээр хөгжүүлэх бодлого, зүүн хойд бүс нутгийн хуучин аж үйлдвэрийн баазыг шинэтгэн хөгжүүлэх бодлого, төвийн бүс нутгийг сэргээн хөгжүүлэх стратеги зэргийг дараа дараалан дэвшүүлсэн юм. Дөрвөн том бүс нутгийг хөгжүүлэх энэхүү стратеги нь хятадын эдийн засгийг үе шаттайгаар, бүсчлэн хөгжүүлэх ерөнхий стратегийн төлөвлөгөөг бүрдүүлсэн бөгөөд энэ нь хятадын эдийн засгийн хөгжил, нийгмийн дэвшилд эрин үеийг нээсэн онцгой чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд Хятад Монгол хоёр улсын хамтын ажиллагааны шинэ, таатай хөгжлийн хандлага буй болж байна. Монгол улсын баруун бүс нутаг болон Хятадын СУӨЗО хоорондын хэлхээ холбоо улам бүр нягтарч, харилцаа улам бүр ойртож байна. Хятадын СУӨЗО хийгээд Монголын баруун бүсийн аймаг аль алин нь найрамдалт харилцаа тогтоон хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Монголын баруун бүс нутгийн удирдагчид, Парламентын гишүүд төлөөлөгчид СУӨЗО-нд олонтаа айлчилж, Монголын бизнесийн салбарынхан Синьзяны Үрэмч хотод зохиогддог худалдааны уулзалтанд идэвхтэй оролцож байна. Синьзян болон Монгол улсын баруун бүс нутаг хил залгаа оршдог, эдгээр бүс нутагт газар зүй, соёл, шашин, нийгмийн хөгжил зэрэг олон талаар адил төстэй зүйл цөөнгүй буй. Хоёр улсын баруун бүс нутгийн хамтын ажиллагааны хэтийн төлөв асар өргөн ирээдүйтэй болох нь эргэлзээгүй юм.

Түүнээс гадна, сүүлийн хоёр жилд Монголын үйлдвэр худалдааны салбарынхан Хятадын Жилинд болсон Зүүн хойд Азийн худалдаа хөрөнгө оруулалтын яармагт оролцлоо. Хятад Монголын баруун бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэхийн зэрэгцээ, бас зүүн бүс нутагт хамтын ажиллагааны талбар буй болгож чадваас, хоёр улс бүх талаар цэцэглэн хөгжих таатай байдал буй болно гэж бодож байна.

Асуулт: Монгол, Хятад хоёр орны найрамдалт харилцаа, хамтын

ажиллагааны хэтийн төлөвийг та хэрхэн төсөөлж байна вэ?

Гао Шумао: Хятад, Монгол хоёр улсын хооронд улс төр, эдийн засаг, соёл хийгээд аюулгүй байдал зэрэг бүх салбарт хамтын ажиллагааны өргөн уудам орон зай, таатай сайхан хэтийн төлөв байна.

Хятад улс “хөршдөө тус хүргэж, хөрштэйгээ түнш байх” хийгээд “найрсаг хөрш, амгалан хөрш, баян хөрш” хэмээсэн хөрш орнуудын гадаад бодлого боловсруулан хэрэгжүүлж байна. Бид Монгол улстай хамтран хөгжиж, эе найртай зэрэгцэн оршсон сайн хөрш, сайн анд, сайн түнш байхыг эрмэлздэг.

Өнгөрсөн зууны 50-иад онд, Хятадын засгийн газар тухайн үеийн олон улсын орчин нөхцөл, улс төрийн байдлыг иш үндэс болгон, “энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг” дэвшүүлсэн юм. Энэхүү бодлогыг хагас зуун илүү хугацаанд тууштай баримтлан, дэлхийн улс орнуудын нийтлэг даган мөрдөх зарчим болж байлаа. Хүйтэн дайн эцэс болсоны дараа, ялангуяа олон улсын харилцаанд шинэ хөгжил буй болсон өнөө үед, Хятадын засгийн газар зохиролт дэлхий ертөнцийн тухай үзэл онолыг тодорхойлон дэвшүүлж байна. Бидний оршин буй дэлхий ертөнц энх тайван хамтын ажиллагааны, тогтвортой хөгжин цэцэглэсэн дэлхий байх ёстой, эе найртай зэрэгцэн оршиж, гар барилцан хамтдаа хөгжсөн дэлхий байх ёстой. Хятад, Монгол хоёр орны харилцааны тухайд, Хятадын засгийн газар хийгээд хятадын ард түмэн мөн нэгэн адил эе найртай зэрэгцэн оршсон, эрх тэгш харилцан ашигтай үндсэн дээр, хоёр талын тогтвортой хөгжин мандсан, сайн хөршийн харилцан итгэлцсэн түншлэлийн харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэж байна.

Хятад, Монгол хоёр улсын харилцааны ирээдүй хойшдын хөгжил цэцэглэлд би бүрэн итгэдэг.

-Манай урилгыг хүлээн авч сонирхолтой ярилцлага өгсөн танд их баярлалаа.

МОНЦАМЭ Агентлагийн хятад хэлээр гардаг “Мэнгу сяоси бао” (Монголын мэдээ) сонины эрхлэгч **М.ЧИМЭДЦЭЕЭ**